

Б.Лхагвасүрэн: Ирээдүйд бий болох томоохон өсөлтийн суурийг бэлтгэхэд энэ хөтөлбөр чиглэж байгаа

Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэнтэй банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөрийн тухай ярилцлаа.

-Хямралд банкны салбар хамгийн их нэрвэгдсэн гэдэг. Тиймээс банкны салбарт шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүссэн гэж ойлгогдож байгаа. Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөрийн явц ямар байна вэ?

-Банкны секторт бүтцийн өөрчлөлт хийх гэдэг бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт юм. Монголын банкны салбарт хийх гэж буй арга хэмжээг энэ ойлголтын хүрээнд хийж байгаа ажил гэж үзэж болно.

Бид хямралыг гэтлэн давлаа. Ирээдүйд эдийн засгийн өсөлтийн “гэрэл” харагдаж байна. Энэ оны хагас жилийн байдлаар аж үйлдвэрийн салбарт том өсөлт гарч ирлээ. Тиймээс эдийн засаг сэргэж буй энэ цагт манай банкны салбар бэлэн байна уу, хэрэв бэлэн бус бол бэлтгэлийг хэрхэн хангах вэ гэдэгт хөтөлбөрийн зорилго чиглэгдэж байгаа юм. Үүнийг банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх гэж байна гэж шууд ойлгох хэрэггүй.

АНУ болон Европын улсууд хямрал эхэлж байхтай зэрэгцэн хямралыг хэрхэн хохирол багатайгаар гэтлэн давах вэ гэж банкны системийн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрөө хэрэгжүүлсэн. Монгол Улс санхүү, эдийн засгийн хямралыг гэтлэн давчихаж байгаа учраас дараачийн томоохон өсөлтийн суурийг бэлтгэхэд хөтөлбөрөө чиглүүлж байгаагаараа түүнээс ялгаатай. Энгийн үгээр тайлбарлавал, хэрвээ аливаа банк өөрийн асуудлаа дангаар шийдэж чадахгүй бол тодорхой хугацаанд төрөөс дэмжлэг үзүүлж гэсэн санаа юм.

-Банк бол хувийн бизнес. Гэтэл төр хувийн салбарын үйл ажиллагаанд хэт оролцож бужигнуулах гээд байгаа юм биш үү?

-Зарчмын асуудал бий. Монгол Улсын санхүүгийн салбар гэсэн нэгдмэл тогтолцооны хүрээнд авч үзвэл хуулийн дагуу ажиллахыг шаардах эрх нь төрд байгаа. Энэ хөтөлбөр банкинд бүтцийн өөрчлөлт хийж бужигнуулах зорилгыг агуулаагүй. Банкны сектор нь эдийн засгийн түлхэх хүч байх ёстой. Ийм агуулгаар нь дэмжих гэж байгаа юм.

-Монголын банкны салбарт зайлшгүй шаардлагатай гэж үзэж буйн шалтгаан нь юу вэ?

-с Зөвшөөрөл авсан дотоодын 14 банк манайд үйл ажиллагаа явуулж байгаа. Оюутолгойн, Таван толгой, тэдгээрийн дэд бүтцийн гээд олон төсөл хэрэгжиж эхлэхэд эргэлдэх мөнгө нь манай ДНБ-ийг хэд дахин нугалах хэмжээтэй болно. . Гэтэл манай арилжааны банкууд ийм томоохон төсөлд оролцож, банкны үйлчилгээг үзүүлэх чадавх байна уу гэхээр жижигдэж байгаа нь үнэн. . , Тухайлбал, энэ оны хувьд манай банкууд бодит эдийн засагт зээл гаргаж өсөлтийг нь дэмжиж чадаж байна уу гэвэл мөн чадахгүй л байна. Өнөөдөр банкууд Монголбанкны үнэт цаасанд 600-гаад тэрбум төгрөгийн р эх үүсвэрээ байршуулчихаад бодит эдийн засаг руу гаргахгүй байна. Төвбанкны үнэт цаасны хүү 11 хувь, арилжааны банкны зээлийн хамгийн бага хүү нь 18-20 хувь байгаагаас харахад банкууд орлогоо алдаж байна. Банкуудын үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа мөртлөө хамгийн гол үйл ажиллагаа болох зээл олголт нь бараг зогсонги байна. Өмнө оолгосон зарим зээлүүдийн чанар муудаж ихээхэн хэмжээгээр эрсдэлийн сан байгуулаад ахин байгуулах болоход өөрийн хөрөнгийн дутагдалд орох эрсдэл магадлал өндөр байгааг харуулж байна. . Иймээс хэрэгцээтэй хүмүүст нь шинэ зээл гаргахын тулд банкууд өөрийн хөрөнгийн харьцааг хангалттай хэмжээгээр нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ байна. .

-Өөрийн хөрөнгийн үзүүлэлт нь ямар байх ёстой юм бэ?

-Банк бол итгэлцлийн байгууллага. Нэг хүнээс хадгаламж авч нөгөө хүнд зээл олгодог. Энэхүү бизнесийг хийхийн тулд банк, банкны эзэдийн оруулах хөрөнгө нь арван хоёр хувиас доошгүй байх, бусдаас татсан хөрөнгө нь үллдэх буюу 88 хувь байх жишээтэй. Үүнээс доош орж болохгүй гэсэн олон улсын стандарт бий. Гэтэл манай зарим банкууд энэ үзүүлэлтээ дөнгөн данган хангаж байна.

-Банкны салбарын чадавх сул байгаа гэж Таны ярианаас ойлгогдож байна. Энэ нь зөвхөн өөрийн хөрөнгөтэй хамаатай юу?

-бүр сул дорой байна гэж хэлж болохгүй. Өнөөдөр зохистой харьцааны үзүүлэлтээ дөнгөж хангаж байна гэсэн үг. Тодорхой нөөц байж л хөгжил, өсөлт бий болно шүү дээ. Нөөц байна гэдэг бол боломж илүү байна гэсэн үг. Эдийн засгийн томоохон өсөлт бий болж байгаа энэ үед банкууд бэлтгэлтэй байж л гадна, дотнын банкуудтай өрсөлдөж, үйл ажиллагаа нь ашигтай байх юм.

-Татвар төлөгчдийн мөнгөөр аливаа нэгэн бизнесийг дэмжих үйл явцаас хүмүүст хардлага төрдөг. Үүнээс ямар нэгэн алдагдал гарч ирж болох юм.

-Татвар төлөгчдийн мөнгийг банкны секторт ашиглаад ямар нэгэн хохирол хүлээх вий гэсэн болгоомжлол байхыг үгүйсгэхгүй. Төрөөс 2-7 жилийн хугацаатай дэмжлэг үзүүлнэ. Хоёр жилийн дараа оруулсан мөнгийг гаргах эсэхийг банкны эздээс асуугаад, хэрвээ мөнгийг нь гаргаж чадахгүй гэвэл төр өөрийн оролцоог

хувьчлах замаар анхны оруулсан хөрөнгөө буцаагаад авчих боломжтой юм. Тиймээс татвар төлөгчдийн мөнгө алдагдахгүй. Мөн төр өөрийн мөнгийг ашиглуулж байх хоёр жилийн хугацаанд тодорхой хэмжээний хүүг тооцож авна.

-Нэг талаас төр дэмжиж байгаа хэрнээ нөгөө талаас хариуцлагыг нь өндөрсгөх арга хэмжээ гэж ойлгож болох нь ээ.

-Болно. Энэ оны нэгдүгээр сард УИХ-аас Банкны тухай хуулийг шинэчлэн баталсан. Ингэснээр Монголбанкны хяналт шалгалтын бодлогыг чангатгах, банкны зохистой удирдлагыг сайжруулах, банкны санхүүгийн тайлан болон өмчлөлийн тухай мэдээллийн ил тод байдлыг хангах гээд олон дэвшилттэй заалтыг тусгасан байгаа. Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөр бол энэ хуулийг хэрэгжүүлэхэд зориулагдсан арга хэмжээ гэж үзэж байгаа. Мэдээж нэг өдөр бүхнийг өөрчлөх боломж байхгүй. Тиймээс хуулийн дагуу өөрийн үйл ажиллагаагаа сайжруулах боломжтой хугацааг ч мөн тусгасан. Олон талын нааштай үр дүн авчрах хөтөлбөр гэж үзэж байгаа.

-Хэдийнээс хэрэгжих боломжтой вэ?

-Хөтөлбөрийн төсөл бэлэн болчихсон. Татвар төлөгчдийн мөнгөөр дэмжлэг үзүүлэх тул УИХ-аас тодорхой шийдвэр гарах учиртай. Өөрөөр хэлбэл, төрөөс хэдий хэмжээний дэмжлэг үзүүлэх вэ гэдэг тоог шийднэ гэсэн үг. Одоо тэр ажил л үлдчихээд байгаа.

-Банк бол эмзэг салбар. Өнөөдрийн бүтцийн өөрчлөлт хийх ажил багагүй эсэргүүцэлтэй тулж байгаа нь нууц биш. Анхнаасаа арилжааны банкуудын зүгээс саналыг нь авч, ойлголцож ажиллаж болоогүй юм уу?

-Энэ хөтөлбөрийг нууж байгаад гэнэт нэг өдөр гаргаж ирээгүй л дээ. Боловсруулах явцад Банкны холбоогоор дамжуулж, бүх банкинд төслөө танилцуулан, саналыг нь авсан байгаа. Хэт чанга заалт байна, ганцхан арга хэрэгслээр явах гэж байна гэх шүүмжлэл гарч байсан.

-Хадгаламжийг төрөөс зуун хувь дааж байсан тогтолцоог өөрчилж, тодорхой хязгаар тавих тухай уг хөтөлбөрт тусгасан. Цаг хугацааны хувьд хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих болсон тухай Төвбанк үзэж байгаа. Үүний давуу тал нь юу вэ?

-Санхүү, эдийн засгийн хямрал нүүрлэх үед УИХ-аас Хадгаламжийн баталгааны тухай хуулийг гаргасан. Банкны итгэл суларч байсан үед үүргээ гүйцэтгэсэн чухал арга хэмжээ болсон. Олон улсын жишгээр төрөөс хадгаламжинд 100 хувийн баталгаа гаргадаг хэлбэр нь хямралын үед авдаг богино хугацааны арга хэмжээ байдаг. Гэтэл одоо энэ арга хэмжээний үйлчлэх хүрээ багасаж, зорилго нь биелсэн тул цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй. Тиймээс хязгаарлагдмал даатгалын тогтолцооны хувилбарыг санал болгож байгаа юм. Энэ

нь 100 хувь төрөөс даах биш, хадгаламжийн даатгал эрхэлсэн төрийн байгууллагаар иргэдийн хадгаламжийн тодорхой хэсгийг даатгах тогтолцоо юм. Жишээлбэл, Тодорхой хязгаарын хүрээнд даатгана гэвэл тэр хэмжээгээр нийт хадгаламж эзэмшигч бүхлээрээ хамрагдана. Сая төгрөгийн хадгаламжтай хүн ч адил, 100 сая төгрөгийн хадгаламжтай ч адил 10 сая төгрөгийг нь төрөөс даах бол тэр хэмжээнд байгаа нь бүхэлдээ хамрагдаж илүү гарсан хэсэг нь хамрагдахгүй гэсэн үг.

Хадгаламжийн даатгалын тогтолцоонд шударга, тэгш зарчим үйлчилнэ. Засгийн газар юм уу, Монголбанкны дунд хадгаламжийн даатгалын компани байгуулж, банкууд өөрсдийн татсан хадгаламжийн хэмжээгээр тодорхой шимтгэл, хураамж төлж даатгал авна. Төр дааж байгаа хэлбэр биш, банк нь хадгаламжаа даатгуулж буй хэлбэр болно. Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг Засгийн газарт өргөн барьсан байгаа.

-Манай банкуудын мэдээлэл хаалттай байдаг. Мэдээллийг ил тод байлгах талаар хөтөлбөрт тусгасан зүйл бий юү?

-Энэ талаар нэлээд сайн тусгасан байгаа. Манай банкуудын хувь нийлүүлэгчдийн мэдээлэл нууц гэдэг. Тиймээс тухайн банкны эзэн хэн бэ, хамгийн том хувь нийлүүлэгч нь хэн бэ гэсэн мэдээлэл байдаггүй. Банк албан ёсоор мэдээлж байх үүргийг хуулиар хүлээж байгаа. Улирал бүр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргадаг санхүүгийн тайландаа эзэмшигчийн тухай мэдээллийг багтаах үүрэгтэйг заасан.

-Хадгаламжийн төрөөс зуун хувь дааснаар татвар төлөгчдийн мөнгийг хэн нэгний буруутай үйл ажиллагааг тэтгэх хэрэгсэл боллоо гэсэн шүүмж байдаг шүү дээ. Яг энэ нөхцөлд дүгнэлт хийж үзсэн үү?

-Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард “Зоос” банкиг татан буулгаж, төр харилцах, хадгаламжийг даасан гэдгээр 100 тэрбум төгрөгийн бонд гаргасан. Гэхдээ 100 тэрбум төгрөгийн бонд гаргаад тийм хэмжээний алдагдал хүлээсэн юм биш. Энэ бол “Зоос” банкиг татан буулгахад гарч байгаа эхний зардал юм. “Зоос” банкинд байгаа муу зээлийг Монголбанкнаас томилогдсон Эрх хүлээн авагч сайн төлж барагдуулж чадвал энэ зардал эргэн нөхөгдөж, төсөв, татвар төлөгчдөд хохиролгүй болно.

Одоо яригдаж байгаа хөтөлбөр бол дахин ийм зардал гаргуулахгүй байх үүднээс зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ болохыг илтгэж байгаа юм.

